

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /4/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Оюунтуяа
Утас: 70350757 Цахим хаяг: oyuntuya0428@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

<u>1. Аудитын санал дүгнэлт</u>	2-4
<u>2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл</u>	5-8
<u>3. Аудитын тайлан</u>	9-11
<u>3.1 Ерөнхий зүйл</u>	12
<u>3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт</u>	13
<u>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал</u>	14
<u>3.4 Материаллаг байдал</u>	14
<u>3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга</u>	15
<u>3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв</u>	15
<u>3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг</u>	15
<u>3.8 Аудитын гол асуудал</u>	16
<u>3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</u>	16
<u>3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</u>	16
<u>3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал</u>	17
<u>4. Аудитын илрүүлэлт</u>	17
<u>5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл</u>	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.03.15 № 105
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТ ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨААТҮГ-ИЙН
ЗАХИРАЛ Г.ЭНХБАЯР
ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт ШУТП ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэт ШУТП ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Эрдэнэт ШУТП ОНӨААТҮГ нь тайлант онд Технологи дамжуулах үйл ажиллагааг эхлүүлж нэг бизнес эрхлэгчид технологийн зөвлөх үйлчилгээ үзүүлэн мөн судалгаа, үйлдвэрлэлийн цогцолборын бизнес инкубатор-1 барилгыг ашиглалтанд хүлээн авсан. Шингэн шил, төрөл бүрийн цавууны үйлдвэрлэлийн технологи боловсруулан, будгийн нөөц түүхий эдээр үйлдвэрлэл явуулж худалдаалсан, хүнд элементийн сорилтын ажлууд хийгдсэн байна.

Өмнө олгосон эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтуудыг амжилттай төвлөрүүлсэн, шинээр 40 бизнес эрхлэгчид хөрөнгө оруулалт олгосон, орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх, ажлийн байр нэмэгдүүлэх чиглэлээр тоног төхөөрөмж ашиглуулах ТЭЗҮ боловсруулах, хэрэгжүүлэх судалгаа үйлдвэрлэлийн цогцолборыг өргөтгөх хөрөнгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлуулан ажилласан байна.

Аж ахуй нэгж байгууллагад бизнес ширээгээр дамжуулан давхардсан тоогоор нийт 132 иргэнд Гарааны бизнес, үйлвэрлэлийн төсөл боловсруулах сургалтад хамруулан ажилласан, өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгч иргэдийн санал хүсэлтэд тулгуурлан Төгөл, Баян худалдааны төвд байрлах “Эрдэнэтэд үйлдвэрлэв” дэлгүүрүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 42 үйлдвэрлэл эрхлэгчтэй гэрээ байгуулан ажиллаж 28,200,000 төгрөгийн бараа бүтээглэхүүн борлуулж дансанд төвлөрүүлэн мөн оёдлын үйлдвэрлэлийн анхан дунд шатны үнэ төлбөргүй сургалтад жилийн төлөвлөгөний дагуу 61 иргэнийг хамруулж, сургалтыг зохион байгуулан мэргэжилийн үнэмлэх олгож, нэмэлтээр гүнзгийрүүлсэн сургалтад 20 иргэнийг монгол европ хувцасны эсгүүрийн чиглэлээр сургаж, сертификат олгосон. Сургалтаас олж авсан мэдлэг мэргэжилээрээ 11 иргэн үйлдвэрлэл хийж, ажлын байрыг шинээр бий болгон ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	428,320,961.15	876,136,163.22
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,114,790.57	270,236,103.22
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,114,790.57	270,236,103.22
3121	Төгрөг	9,114,790.57	
31211	Төрийн сангийн харилцах		
31212	Монгол банкин дахь харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах	9,114,790.57	270,236,103.22
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		
33	АВЛАГА	384,380,794.89	576,500,364.85
33401	Дансны авлага /ТӨҮГ/	42,500,000.00	70,395,000.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	589,794.89	35,364.85
336	Зээлийн авлага	341,291,000.00	506,070,000.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	341,291,000.00	506,070,000.00
33611	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
33612	Хувь хүмүүст олгосон зээл	341,291,000.00	506,070,000.00
34714	Томилолтын урьдчилгаа		
35	БАРАА МАТЕРИАЛ	34,825,375.69	29,399,695.15
351	Түүхий эд материал	17,233,645.97	14,470,372.73
35110	Тусгай зориулалттай материал	17,233,645.97	14,470,372.73
35130	Эм боох материал		
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	4,198,480.89	
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,637,000.00	1,482,000.00
354	Хангамжийн материал	11,756,248.83	13,447,322.42
35470	Бусад хангамжийн материал	11,756,248.83	13,447,322.42
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	843,251,048.71	847,947,211.13
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	100,000,000.00	100,000,000.00
371	Урт хугацаат хадгаламж	100,000,000.00	100,000,000.00
37110	Төгрөг	100,000,000.00	100,000,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	743,251,048.71	747,947,211.13

391	Газар		
392	Биет хөрөнгө	741,408,826.59	746,507,211.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	447,794,300.00	447,794,300.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,926,476.72)	(22,389,715.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,000,000.00	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,458,333.17)	(11,958,333.10)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	315,588,847.94	356,130,784.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,415,077.96)	(112,767,577.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,490,127.73	59,002,855.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,353,692.57)	(20,393,911.35)
39209	Зам, гүүрийн байгууламж		
39214	Бусад үндсэн хөрөнгө	46,439,445.46	58,209,718.19
39215	Хуримтлагдсан элэгдэл	(37,750,314.12)	(42,120,909.73)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном		
393	Биет бус хөрөнгө	1,842,222.12	1,440,000.00
39301	Програм хангамж	3,800,000.00	3,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,957,777.88)	(2,360,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,271,572,009.86	1,724,083,374.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,609,017.37	540,583,255.68
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,609,017.37	540,583,255.68
413	Өглөг	19,609,017.37	540,583,255.68
41350	Зээлийн хүүгийн өглөг		
4136	Бусад өглөг	19,609,017.37	540,583,255.68
41361	Байгууллагад төлөх өглөг		540,000,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	19,609,017.37	583,255.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,251,962,992.49	1,183,500,118.67
51	Засгийн газрын хувь оролцоо	1,251,962,992.49	1,183,500,118.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,150,103,063.75	1,184,058,063.75
51101	Өмч: - төрийн	1,150,103,063.75	1,150,103,063.75
51102	- хувийн		

51103	- хувьцаат		
51104	Халаасны хувьцаа		
51105	Нэмж төлөгдсөн капитал		
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		33,955,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	101,859,928.74	(557,945.08)
51210	Өмнөх үеийн үр дүн	(77,235,364.87)	-
51220	Тайлант үеийн үр дүн	179,095,293.61	(557,945.08)
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,271,572,009.86	1,724,083,374.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	485,162,231.70	126,918,228.81
114003	НӨАТ-ын буцаан олголт		
115	Онцгой албан татвар	-	-
118304	Нохойны албан татвар		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	485,162,231.70	126,918,228.81
120	Нийтлэг татварын бус орлого	485,162,231.70	126,918,228.81
120001	Хувьцааны ногдол ашиг		12,500,000.00
120002	Хүүгийн орлого		
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	575,993,981.83	164,702,818.17
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	(90,831,750.13)	(50,284,589.36)
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/		
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	306,109,026.15	229,336,102.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	306,109,026.15	229,336,102.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,109,026.15	229,336,102.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	306,109,026.15	229,336,102.62
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	16,291,633.83	9,998,496.21
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	227,533,343.06	183,668,151.86
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	4,895,454.55	1,800,000.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	37,489,117.64	33,869,454.55
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	19,899,477.07	
223001	Бусад хөрөнгө		
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	179,053,205.55	(102,417,873.81)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>179,053,205.55</u>	<u>(102,417,873.81)</u>

2.3 Аудит хийсэн санхүүгийн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	537,399,816.25	683,207,363.62
114003	НӨАТ-ын буцаан олголт		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	537,399,816.25	683,207,363.62
120	Нийтлэг татварын бус орлого	537,399,816.25	683,207,363.62
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого	42,088.06	
120003	Торгуулийн орлого		
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	537,357,728.19	683,207,363.62
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	476,352,436.46	241,937,114.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	476,352,436.46	241,937,114.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	476,352,436.46	241,937,114.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,858,800.91	62,160,856.51
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	69,858,800.91	62,160,856.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,865,731.00	19,082,225.23
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	20,865,731.00	19,082,225.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,182,846.31	10,401,061.84
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	22,182,846.31	10,401,061.84
2104	Хангамж, бараа материалын зардал	92,040,869.86	47,895,297.39
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	7,210,870.72	4,590,173.73
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	84,829,999.14	43,305,123.66
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	271,404,188.38	102,397,673.64
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	13,608,812.51	29,255,482.57
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	65,340.00	
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	257,730,035.87	73,142,191.07
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр		
212	ТАТААС	-	-

2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>61,047,379.79</u>	<u>441,270,249.01</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	12,500,000.00
140008	Хүлээн авсан ногдол ашиг		12,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	52,703,090.91	27,869,936.36
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,703,090.91	27,869,936.36
2200	Дотоод эх үүсвэрээр	52,703,090.91	27,869,936.36
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	52,703,090.91	27,869,936.36
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(52,703,090.91)</u>	<u>(15,369,936.36)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-	80,221,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		80,221,000.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	245,000,000.00
250001	Гадаад валютын ханшийн зөрүү		
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		245,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	<u>(164,779,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,344,288.88	261,121,312.65
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	770,501.69	9,114,790.57
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,114,790.57	270,236,103.22

2.4 Аудит хийсэн санхүүгийн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,150,103,063.75	28,610,589.04	1,178,713,652.79
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,150,103,063.75	28,610,589.04	1,178,713,652.79
C07	Тайлант үеийн үр дүн		179,095,293.61	179,095,293.61

C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,150,103,063.75		1,150,103,063.75
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,150,103,063.75	101,859,928.74	1,251,962,992.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,150,103,063.75		1,150,103,063.75
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			33,955,000.00
D08	Тайлант үеийн үр дүн		-102,417,873.81	-102,417,873.81
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,150,103,063.75	-102,417,873.81	1,183,500,118.68

ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Д/д	Орлогын нэр	Орлогын төлөвлөгөө	Орлогын гүйцэтгэл
1	2021 оны харилцахын эхний үлдэгдэл	10,000,000.00	9,114,791
2	2021 оны менежментийн үйл ажиллагааны орлого	50,000,000.00	54,160,000
ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ 90% БИЕЛЭЛТТЭЙ			

ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Д/д	Зардлын нэр	Зардлын төлөвлөгөө	Зардлын гүйцэтгэл
1	Ажиллагчдын цалин	79,800,000	71,793,042
2	Аж ахуй нэгжээс төлсөн НДШ	10,932,600	10,424,420
3	Шуудан холбоо	1,500,000	859,324
4	Ус, дулаан, цахилгааны зардал	15,000,000	14,892,980
5	Түрээсийн зардал	22,357,000	20,718,000
6	Шатахууны зардал	4,000,000	3,977,230
7	Хангамж, түүхий эд материалын зардал	56,500,000	54,680,851
8	Сургалт судалгаа, туршилтын ажил гүйцэтгүүлэх	25,000,000	23,560,500

9	Тоног төхөөрөмж, бизнес инкубатор төвийн камержуулалт	28,100,000	28,297,300
10	Тээврийн зардал	2,000,000	1,200,000
11	Ажлын байр дэмжих төсөл хөтөлбөр "Гарааны бизнес-2021"	190,000,000	190,000,000
12	Жижиг, дунд бизнест хөрөнгө оруулалт	160,000,000	55,000,000
13	Санхүүгийн програмын лиценз	385,000	385,000
14	Санхүүгийн тайланд аудит хийлгэх зардал	1,500,000	1,800,000
15	Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх	3,500,000	3,000,000
16	Ахмадын сан	200,000	200,000
17	Байгаль орчныг хамгаалах	200,000	126,000
18	Татварын зардал	21,410,000	21,347,719
19	Хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал болон бусад зардал	60,000,000	62,946,580
Нийт зардал		682,384,600	565,208,947
ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ 82% БИЕЛЭЛТТЭЙ			

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 02-наас 2022 оны 03 дугаар сарын 11-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Оюунтуяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ийн 2021 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас дотоод аудит, хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 127,125.6 мянган төгрөгөөс 2 хувиар тооцож 2,542.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,034.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлаггүй гэж үзлээ.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэт шинжлэх ухаан, технологийн парк ОНӨААТҮГ нь 2017 оны 04 дүгээр сараас шинжлэх ухаан, техник технологийн судалгаа, инновацийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, гарааны бизнес хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагааг явуулах зорилготой ажиллаж байна. 2017-2021 онд судалгаа шинжилгээний үр дүнд өөрийн бүрэлдэхүүнд 3 үйлдвэрлэл үйлчилгээний нэгж байгуулсан ба Өрхийн болон бичил үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ,

залуучуудийн гарааны бизнесийг дэмжих чиглэлээр нийт 258 иргэн аж ахуй нэгж байгууллагад гарааны бизнесийн эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт олгож ажилласан байна.

“Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк” ОНӨААТҮГ-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Суурь судалгааны ажил болон орон нутгийн захиалгатай шинжлэх ухаан, технологийн төслийг судлах олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих зохицуулалт хийх, тайлан тэнцлийг гаргуулан авч дүн шинжилгээ хийх, илэрсэн зөрчил дутагдалыг арилгах.

2. Орон нутгийн хэмжээнд төрийн бус байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэдэд сургалт явуулах инновацийн үйл ажиллагаа эрхлэх.

3. Шинжлэх ухаан, технологийн төслийн суурь судалгааны сэдэвт ажлын өртөг, зардлыг нарийвчлан хянаж батлуулах.

4. Шинжлэх ухаан, технологи, инновацийн төслийн захиалагч, гүйцэтгэгч байгууллагатай шинжлэх ухаан технологийн болон инновацийн төсөл хэрэгжүүлэх гүйцэтгэлд нь хяналт тавих хэрэгжүүлж дууссан төслийн бүртгэл хөтлөх.

5. Эрдэм шинжилгээ судалгаа, туршилтын ажлын үр дүнг хуулийн этгээдээр дамжуулан үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэхэд үзүүлэх, гэрээгээр хамтарч ажиллах, гадаад орны шинжлэх ухааны парк, түүнтэй адилтгах байгууллагуудтай хамтарч ажиллах хамтарсан суурь хавсрага судалгааны төсөл хэрэгжүүлэх санхүүжүүлэх, шинжлэх ухааны ололтыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах, эрдэм шинжилгээний хурал, төслийн уралдаан, хэлэлцүүлэг зөвөлгөөн семнар, үзэсгэлэн зохион байгуулах.

6. Орон нутгийн засаг захиргааны байгууллага, аж ахуй нэгж иргэдээс захиалсан төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэх.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит ААТҮГ гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ нь Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2016 оны 11 сарын 28-ний 135 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлийн 5-д “Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавина” гэсэн заалттай нийцэж байна. Тус байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд Ноён программыг ашиглалтад оруулж, тус программд нэвтрэх 2 эрхтэй ажилтантай бөгөөд ерөнхий нягтлан бодогч, нярав нар өдөр тутмын ажил гүйлгээг оруулсан байна. Үндсэн хөрөнгийн эд хариуцагч бүрийн нэрийг хөрөнгө бүрийн ард тусгаж санхүүгийн программд бүртгэж өгсөн нь хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авсан байна. Дотоод зохион байгуулалтын хүрээнд жирэмсэн амаржсаны чөлөөтэй байгаа 2 ажилтны оронд шинээр ажилтан аваагүйгээс хамаарч цалингийн зардлыг 15,600.0 мянган төгрөгөөр хэмнэсэн, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардлыг тайлант онд гаргаагүй зэрэг нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өөрчлөлт орсон.
- ТБОНӨХБАҮХАТХууль 2021 онд өөрчлөлт орсон.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,114.7	270,236.1	263,121.4
УХХО	100,000.0	100,000.0	
Авлага	384,380.8	576,500.4	192,119.6
Бараа материал	34,825.4	29,399.7	(5,425.7)
Үндсэн хөрөнгө	894,312.7	956,137.6	61,824.3
Нийт хөрөнгийн дүн	1,422,633.6	1,932,273.8	509,640.2
Өр төлбөрийн дүн	19,609.0	540,583.2	520,974.2
Богино хугацаат өглөг	19,609.0	540,583.2	520,974.2
Эздийн өмч	1,251,962.9	1,183,500.1	(68,462.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,271,572.0	1,274,083.3	2,511.3

Тайлант онд кассаар нийт 119,012.7 сая төгрөгийн орлого орж, 119,012.7 мянган төгрөг зарцуулсан байна. Банкны харилцах дансанд 270,236.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага өмнөх оноос ихэссэн ба Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-с 70,395.0 мянган төгрөг, “Гарааны бизнес” 2019-2021 онд төсөл арга хэмжээ зохион байгуулж, бичил бизнес эрхлэгчдэд хөрөнгө оруулалт олгосонтой холбоотой 506,070.0 мянга төгрөг, ХАОАТ урьдчилгаа төлбөрийн нэхэмжлэл үүсгэж урьдчилан төлсөнтэй холбоотой 35.4 мянган төгрөг, нийт 576,500.4 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 571,800.0 мянган төгрөгийн, хугацаа хэтэрсэн 4,700.0 мянган төгрөгийн зээл байна. Хугацаа хэтэрсэн шалтгаан нь өрхийн болон бичил бизнес эрхлэгчид “Ковид-19” цар тахалтай холбоотой үйлдвэрлэл бараа бүтээгдэхүүний борлуулалт багасаж, эргэн төлөлтөө хугацаандаа төвлөрүүлж чадаагүй хүндрэл үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 29,399.7 мянган төгрөг болж 5,425.7 мянган төгрөгөөр буурсан нь ашиглагдахгүй элэгдэл ихтэй бараа материалыг зарлагадсан байна.

Тайлант онд худалдан авалтаар 11,356.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 5,872.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 10,640.3 мянган төгрөгийн бизнес инкубатор төвийн иж бүрэн камер, Орхон аймгийн Засаг даргын 2021 оны 02 сарын 18-ны өдрийн А/83 дугаар захирамжийн дагуу үнэ төлбөргүй хүлээн авсан 29,185.0 мянган төгрөгийн машин

тоног төхөөрөмж, 3,640.0 төгрөгийн тавилга эд хогшил, 1,130.0 мянган төгрөгийн компьютер дагалдах хэрэгсэл балансад шилжүүлж бүртгэжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 540,583.3 мянган төгрөг байна. Өр төлбөр үүссэн шалтгаан нь Бичил болон өрхийн үйлдвэрлэгчдэд хөрөнгө оруулалт олгосонтой холбоотой мөн Германы олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, хөгжүүлэх, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг сайжруулах зорилгоор бизнес эрхлэгчидэд тоног төхөөрөмжийн буцалтгүй хөрөнгө оруулалт олгосонтой холбоотой өр төлбөр үүссэн байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 97,420.0 мянган төгрөгөөр буурсан нь Электродны үйлдвэрийн үйл ажиллагаа хэвийн явагдаагүйгээс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэт ШУТП ОНӨААТҮГ-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 30 дугаар тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 656,000.0 мянган төгрөгөөр, нийт урсгал зардлыг 304,284.6 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 351,715.4 мянган төгрөг байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 591,341.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 291,911.6 мянган төгрөгийн урсгал зардал гарган, 299,429.5 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд төлсөн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Эрдэнэт ШУТП” ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 173 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 11 мэдээллийг хугацаа хоцроож, 162 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ” гэсэн заалтын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 19,491.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс 100 хувийн биелэлттэй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	19,491.0	3	19,491.0			
Нийт дүн	3	19,491.0	3	19,491.0			

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зээл олголт, зээлийн иргэн төлөлтийг нягтлах, бараа материал болон үндсэн хөрөнгөнд тооллого хийх.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,734.37 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

8.1 Залруулсан алдаа: Аудитын явцад залруулсан алдаа байхгүй болно.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 11 удаагийн мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулж цахим хуудаст мэдээлэх мэдээллийг хугацаанд нь бүрэн гүйцэт мэдээлж, дотоод хяналтыг сайжруулах.

2. Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шаардах хуудас хөтөлдөггүй, няравын гаргаж байгаа бараа материалын тайланг нягтлан хянаж баталгаажуулдаггүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажилаагүй нийт 7,144.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад

түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.7.-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгах.

3.Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 4,590.173 мянган төгрөгийн шатахууны зарцуулсан байтал анхан шатны баримт байхгүй, жолоочийн тооцооны хуудсас хөтөлдөггүй, бараа материалын тайланд тайлагнаагүй, шатах тослох материал зарлагдахдаа НХМаягт БМ-6 маягт, НХМаягт Т-4 маягтуудыг хөтөлдөггүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар”-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Автомашин шатахуун зарцуулалтыг үнэн зөв тодорхойлж зарцуулан, анхан шатны баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг бүртгэж, санхүүгийн тайланд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/												
							Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж				
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Санхүүгийн тайлангийн асуудлаар																			
1	"Эрдэнэт ШУТП" ОНӨААТҮГ	ОРА-2022/4/НА/СТА-ТӨХК	Санхүүгийн	Зөвлөмж хүргүүлэв															
2				Шилэн дансны цахим хуудсанд 11 удаагийн мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.															
3				Шаардах хуудас хөтөлдөггүй, няравын гаргаж байгаа бараа материалын тайланг нягтлан хянаж баталгаажуулдаггүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажилаагүй нийт 7,144.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна.															
4				Тайлант онд 4,590.173 мянган төгрөгийн шатахууны зарцуулсан байтал анхан шатны баримт байхгүй, жолоочийн тооцооны хуудсас хөтөлдөггүй, бараа материалын тайланд тайлагнаагүй, шатах тослох материал зарлагдахдаа НХМаягт БМ-6 маягт, НХМаягт Т-4 маягтуудыг хөтөлдөггүй байна.															
5																		3	11,734.37
ДҮН															3	11,734.37			